

## ӨНДӨРХААН ХК-ИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.03.29

Улаанбаатар хот

<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа</i>	2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Өндөрхаан” ХК УБД: 000133505 ОНН, 88889558
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Үр тариа болон бусад ургамал тариалалт, мал аж ахуй
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	Грант Торнтон аудит ХХК СЗХ-д бүртгүүлсэн огноо: 2014.01.29
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	111,879 ширхэг
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Ц.Анударь /ТУЗ-ийн НБД/ Хянасан: О.Амарболд /Гүйцэтгэх захирал/
<i>1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	Манай компани үйл ажиллагаа явуулаагүй ба жилийн эцсийн байдлаар 107,480.4 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэй гарсан.
<i>Орлогын тайлан</i>	Жилийн эцсийн байдлаар 29,824.0 мянган төгрөгийн алдагдалтай гарсан.
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Жилийн эцсийн байдлаар хуримтлагдсан алдагдлын хэмжээ 44,997.0 мянган төгрөгөөр тайлагнагдав.
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Жилийн эцсийн байдлаар мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 500.0 мянган төгрөгөөр тайлагнагдав.
<i>1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>	
	<b>Грант Торнтон аудит ХХК</b>

	<p>Бид “Өндөрхаан” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн байдлын тайлан,</li> <li>- Орлогын дэлгэрэнгүй тайлан,</li> <li>- Өмчийн өөрчлөлтийн тайлан,</li> <li>- Мөнгөн гүйлгээний тайлан болон</li> <li>- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,</li> <li>- Бусад тайлбар тодруулгууд</li> </ul> <p>Бидний дүгнэлтээр, “Өндөрхаан” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.</p>	
2	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
2.1	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт хөрөнгийн өгөөж /ROA/= -0.2775 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/= 0.8821
2.2	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Нийт хөрөнгийн эргэц /ROTA/= -0.2728 Нэгж хувьцааны өгөөж /EPS/ = -266.8182 Үнэ ашгийн харьцаа /P/E ratio/ = 37.8535
2.3	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Бид 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.
2.4	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ гараагүй.
2.5	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд зээл аваагүй.
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	2021 оны 12 дугаар сард нийт 4 их хэмжээний хэлцэл, 1 сонирхолын зөрчилтэй хэлцлийг хийсэн байна. /Тогтоолуудыг хавсаргав/	
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>	
	Компанийн жилийн эцсээрх цалингийн зардал 9.4 сая төгрөгийн дүнтэй гарсан байна. Үйл ажиллагаа явуулаагүй учраас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргад цалин урамшуулал олгоогүй болно.	
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	

	<p>Өндөрхаан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шинээр томилсон.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Г.Цогбадрах</li> <li>2. О.Амарболд</li> <li>3. Б.Гантулга</li> <li>4. Г.Уянга</li> <li>5. Б.Оюутцэцэн</li> <li>6. Г.Сүхбаатар</li> <li>7. Г.Бурмаа</li> <li>8. Т.Билэгсайхан</li> <li>9. Д.Хулан</li> </ol>
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	-
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Э.Пүрэвсүрэн – 32.03%</li> <li>2. Ө.Ашхүү – 32.03%</li> <li>3. Б.Батаа – 17.64%</li> <li>4. Бусад хувьцаа эзэмшигчид – 304 хувьцаа эзэмшигчид 18.3%</li> </ol>
8.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p> <p>Байхгүй.</p>
9.	Ногдол ашигийн мэдээлэл
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн №1 тогтоолоор үйл ажиллагаа явуулаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр ажил хийгдээгүй.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Отгонбаярын Амарболд          Албан тушаал: “Өндөрхаан” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: .....          (Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр: .....          Албан тушаал: “Гранд Торнтон” ХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: .....          (Тамга/тэмдэг)</p>
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Цогтсайхан Анударь          Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга          Гарын үсэг: .....</p>	

# ӨНДӨРХААН ХК

2021 оны 12 сарын 22-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 87 дугаар зүйлийн 87.1.1, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани нэмж хувьцаа гаргахтай холбоотой дараах их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

№	Гэрээний тал	Гэрээний төрөл	Үнийн дүн /төгрөг/
1	"Ард секоритиз ҮЦК" ХХК	Андеррайтингийн үйлчилгээний гэрээ	110,000,000
2	"Хүлэгтхүннү аудит" ХХК	Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ	5,000,000
3	"Грант Торнтон аудит" ХХК	Аудитын үйлчилгээний гэрээ	5,000,000
4	"И Эл Си" ХХН	Хууль зүйн үйлчилгээний гэрээ	11,000,000

2. Компанийг төлөөлөн дээрх гэрээнүүдийг байгуулах, гарын үсэг зурах, хэрэгжилтэд хяналт тавих эрхийг Гүйцэтгэх захирал /О.Амарболд/-д олгосугай.

ДАРГА



Г.ЦОГБАДРАХ

# ӨНДӨРХААН ХК

2021 оны 12 сарын 22-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1.1, 92 дугаар зүйлийн 92.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.31.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлэх, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа авах ажлыг гүйцэтгүүлэхээр компанийн хувьцаа эзэмшигч Ө. Ашхүү (РД:Ш372101471)-тэй Ажил гүйцэтгэх гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Ажил гүйцэтгэх гэрээний үнийн дүнг 228,000 (хоёр зуун хорин найман мянган төгрөг) байхаар тогтоосугай.
3. Ажил гүйцэтгэх гэрээнд компанийг төлөөлөн гарын үсэг зурах, гэрээний бусад нөхцөлийг тохирох эрхийг Гүйцэтгэх захирал (О. Амарболд)-д олгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох санхүүгийн бүртгэлийг хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Б. Ундрал)-д даалгасугай.

ДАРГА



Г.ЦОГБАДРАХ